



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 21 дүгээр зарлиг, Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэд "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах Байнгын ажиллагаатай дэд зөвлөл"-ийг байгуулж, дэд зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэд зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0023100059

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Байнгын ажиллагаатай дэд зөвлөл /цаашид "дэд зөвлөл" гэх/ нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Шадар сайд баталж, үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.2. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын явцтай танилцаж шийдвэр гаргана.

2.3. Дэд зөвлөл нь дарга, орлогч, гишүүд, нарийн бичгийн даргатай байна.

2.4. Дэд зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг орлогч дарга гүйцэтгэнэ.

2.5. Дэд зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ажлын шаардлагаар ээлжит бусаар хуралдаж болно.

2.6. Хэлэлцэх асуудлаас хамааран дэд зөвлөлийн хуралд холбогдох албан тушаалтаныг оролцуулж, өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно.

2.7. Дэд зөвлөлийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.8. Дэд зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж албажуулна.

2.9. Дэд зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байх бөгөөд хэвлэмэл хуудас, тэмдгийг Ажлын алба хариуцна.

2.10. Дэд зөвлөлийн ажлын албаны үүргийг Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн тасаг гүйцэтгэнэ.

2.11. Дэд зөвлөл шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.12. Магнитуд нь 6.5 ба түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт хот, суурин газар болсон үед дэд зөвлөлийн бүрэлдэхүүн дуудлага, зарлалгүйгээр Онцгой байдлын ерөнхий газар, эсхүл Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн даргын заасан газарт цугларна.

Гурав. Дэд зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Дэд зөвлөл дараах эрхтэй байна. Үүнд:

3.1.1. дэд зөвлөл нь үйл ажиллагааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт, албан даалгавар, зөвлөмж гаргана.

3.1.2. Монгол Улсын хууль тогтоомж, Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн салбар зөвлөл, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих;

3.1.3. холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн салбар зөвлөл, байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, биелэлтийг хангуулах;

3.1.4. мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн газар хөдлөлтийн бүс дэх барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил, хүлээн авах, хяналт болон стандарт, норм, дүрмийн шинэчлэлийн талаар мэдээлэл солилцох, хот төлөвлөлт, аюулгүй байдлын талаар хэлэлцэх, чиглэл өгөх.

3.1.5. гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг хяналт тавих, болзошгүй гамшгаас хамгаалах арга хэмжээний чиглэл тогтоох, бэлэн байдлыг хангуулах;

3.2. Дэд зөвлөл дараах үүрэгтэй байна. Үүнд:

3.2.1. газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

3.2.2. аймаг, нийслэлийн Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангах;

3.2.3. газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах анхааруулга, санамж, зөвлөмж болон авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаархи мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх;

3.2.4. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.5. газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах асуудлаар гадаад улс орон, олон улсын байгууллага болон ижил төсөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцах, хамтран ажиллах, туршлага судлах;

3.2.6. газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны талаарх мэдээллийг жил бүрийн 1 дүгээр сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах.

Дөрөв. Дэд зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1. Дэд зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;

4.2. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, гишүүдэд үүрэг чиглэл өгч, биелэлтэд хяналт тавих;

4.3. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагааны талаар дээд шатны байгууллага (ҮАБЗ, УИХ, ЗГ)-д танилцуулах;

4.4. дэд зөвлөлийн хурлыг таслах, хоцрох, зөвлөлийн шийдвэр, төлөвлөгөөний хүрээнд хариуцсан ажлаа тасалдуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох талаар удирдлагад нь мэдэгдэх, хэрэгжилтэд хяналт тавих.

Тав. Дэд зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

5.1. Дэд зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна. Үүнд:

5.1.1. өөрийн хариуцсан чиглэлийн хүрээнд зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн салбар зөвлөл болон хуулийн этгээдээс мэдээлэл авах, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих;

5.1.2. дэд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой санал гаргах;

5.1.3. дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах, хэлэлцүүлэх, тайлагнах;

5.1.4. яам, агентлагт дэд зөвлөлийн төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

5.1.5. хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд урьдчилан мэдэгдэх, хэлэлцэх асуудлын талаарх саналаа бичгээр хүргүүлэх;

5.1.6. дэд зөвлөлийн нарийн бичгийн даргатай үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;

5.2. Дэд зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна. Үүнд:

5.2.1. газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах ажлыг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, түүнд шаардлагатай зардлыг шийдвэрлэх;

5.2.2. дэд зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хуралдаанд идэвхи санаачлагатай оролцох.

5.2.3. дэд зөвлөлийн даргын баталсан төлөвлөгөө, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг дэд зөвлөлийн даргад тайлагнах;

5.2.4. дэд зөвлөлийн гишүүд нь шаардлагатай тохиолдолд өөрийгөө орлох албан тушаалтныг томилж, тухайн албан тушаалтны нэр, холбогдох утас, цахим хаягийг Ажлын албанд албан бичгээр өгөх, өөрчлөлт орох тухай бүр шинэчлэн мэдэгдэж байх;

Зургаа. Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

6.1. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрхтэй байна. Үүнд:

6.1.1. дэд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөлийн гишүүд, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэл, хуулийн этгээдээс мэдээлэл авах, зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

6.1.2. газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зөвлөлийн гишүүдээс дэмжлэг авах;

6.1.3. дэд зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

6.2. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэгтэй байна. Үүнд:

6.2.1. хуралдаанаар хэлэлцэх асуудал, хөтөлбөрийг дэд зөвлөлийн даргаар батлуулах;

6.2.2. хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах, холбогдох яам, агентлаг, байгууллагад мэдэгдэх, хуралдааны ирцийг бүрдүүлэх;

6.2.3. дэд зөвлөлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.2.4. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайланг холбогдох байгууллагаас гаргуулах, нэгтгэн зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

6.2.5. дэд зөвлөлийн Ажлын алба болон гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог хангах;

6.2.6. дэд зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, зохион байгуулалтын зардлын тооцоог зөвлөлийн даргад танилцуулж, шийдвэрлүүлэх;

6.2.7. дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж танилцуулах зохион байгуулсан ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлах ажил зохион байгуулах;

6.2.9. дэд зөвлөлийн баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөх.

Долоо. Дэд зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Дэд зөвлөлийн гишүүд дэд зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргана.

7.2. Дэд зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэн Монгол Улсын Шадар сайд, дэд зөвлөлийн дарга батална.

---oOo---

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: -Монгол Улсын Шадар сайд;
- Орлогч дарга: -Барилга, хот байгуулалтын дэд сайд;
-Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Гишүүд: -Батлан хамгаалахын дэд сайд;
-Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;
-Эрүүл мэндийн дэд сайд;
-Эрчим хүчний дэд сайд;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Нийслэлийн Засаг даргын орлогч;
-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга;
-Үндэсний геологийн албаны дарга;
-Шинжлэх ухааны академийн харьяа Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал;
- Нарийн бичгийн дарга: -Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны ахлах референт;
-Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга;